

Аймгийн биеийн тамир, спортын стратеги
хөгжлийн төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн хуулийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 216 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Биеийн тамир, спортын хөгжлийн стратеги төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Стратеги төлөвлөгөөг аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган, хэрэгжилтийг хангуулж ажиллахыг аймгийн Биеийн тамир, спортын газар (М.Батбаяр)-т үүрэг болгосугай.

3.Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хоёр жил тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Н.Бямбадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ӨНӨРБАЯР

ЗАВХАН АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2025-2028 он)

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэж заасан байдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 100 дугаар тушаал, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтын дагуу аймгийн Биеийн тамир, спортын хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсрууллаа.

Аймгийн Биеийн тамир, спортын хөгжлийн стратеги төлөвлөгөөнд дараах зүйлүүдийг багтаасан.

1. Нийтлэг үндэслэл
2. Мандатын шинжилгээ
3. Алсын хараа
4. Эрхэм зорилго
5. Стратегийн зорилго, зорилт
6. Орчны шинжилгээ
7. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот

түвшин

Биеийн тамир, спортын хөгжлийн стратеги төлөвлөгөөнд стратегийн зорилт буюу хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн гол зорилт, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог гаргаж өгсөн.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Завхан аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2024 - 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилттой уялдуулан хөтөлбөр, арга хэмжээг тодорхойлсон.

Энэхүү төлөвлөгөөний үр дүнд биеийн тамир, спортын үйлчилгээний чанар хүртээмж

сайжирч, иргэдийг эрүүл чийрэг байлгах, тэднийг биеийн тамир, спортоор хичээллэх орчин бүрдүүлэх, их спорт, олимпийн хөдөлгөөнийг сурталчлан дэлгэрүүлэх, тамирчдын залгамж халаа бэлтгэгдсэн байна.

МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандатыг тодорхойлохдоо Монгол Улсын үндсэн хууль болон Биеийн тамир, спортын салбарт шууд хамаарах хуулиуд, Олон Улсын гэрээ, конвенц болон нийтлэг мөрдөх хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд доорх алхмаар хийсэн.

1. Хууль тогтоомжоор олгогдсон чиг үүргийг тодорхойлох
2. Тухайн чиг үүргүүдийг үйл ажиллагааны чиглэлээр ангилахСалбар хоорондын

болон засаглалын түвшин хоорондын холбогдогч талуудын оролцоог тодорхойлох

3. Чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох

Мандатын шинжилгээний үр дүнд 2 ерөнхий чиг үүрэг, 2 үндсэн чиг үүрэг, 10 дэд чиг үүргийг нарийвчлан тодорхойлж доорх хүснэгтэд нэгтгэсэн.

Мандатын шинжилгээний хүснэгт:

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		21
Үүнээс	Тухайн салбарын хуулийн тоо	2
	Нийтлэг мөрдөх хуулийн тоо	11

Ерөнхий чиг үүрэг 1: Биеийн тамир, спорт бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангах

Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1 . Иргэдийн идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлж, эрүүл мэндээ хамгаалах, хичээллэх орчин нөхцлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох	1.Хүн амыг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх үүднээс нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх, эрүүл амьдрах хэв маягт суралцаж, дасгал хөдөлгөөнийг дадал хэвшил болгох иргэдийн тоог нэмэгдүүлэх	Биеийн тамир, спортын улсын хороо, Аймаг, сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Төрийн болон төрийн бус байгууллага, Мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, иргэд
	2.Нийтийн биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлтэй хамтран ажиллах	
	3.Бүх насны иргэдийн дунд биеийн тамир, спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулах	
Ерөнхий чиг үүрэг 2: Спорт бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангах		
2.Спортоор дамжуулан мэргэжлийн тамирчин бэлтгэх, тэмцээн уралдааны тоог нэмэгдүүлж, тамирчид, дасгалжуулагчдын урагш чадварыг дээшлүүлэх, тив дэлхийд орон нутгийн нэрийг гаргах	4.Хөгжлийн бэршээлтэй иргэдийг дэмжиж спортын үйл ажиллагаанд татан оролцуулж, тэдгээрт чиглэсэн биеийн тамирын үйл ажиллагаа, орчин нөхцөлийг сайжруулж хамтран ажиллах	Биеийн тамир, спортын улсын хороо, аймаг, сумын Засаг дарга, Боловсрол, шинжлэх ухааны газар, Спортын

	5.Үндэсний болон өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлж, сургалт дасгалжуулалт, үйл ажиллагааг өргөжүүлэх	холбоодууд, иргэд
	6.Өсвөрийн шигшээ багийн амжилтыг ахиулах зорилгоор спорт холбоодынх нь үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллах	
	7.Спортын төрлүүдийн тоог нэмэгдүүлж, шинээр үйл ажиллагаа явуулж буй спортын холбоодтой хамтран ажиллах	
	8.Баруун бүс болон бусад аймгуудын сайн жишгийг нэвтрүүлж, харилцан туршлага солилцож хамтран ажиллах	
	9.Гадаад харилцааг хөгжүүлж, ажилчид, багш, дасгалжуулагчид, тамирчдынхаа ур чадварыг дээшлүүлэх	
	10.Спортын заал талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, спортоор дамжуулан иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх	

СТРАТЕГИЙН ҮНДСЭН ЗОРИЛТУУД

АЛСЫН ХАРАА

Хүн амын хэрэгцээнд нийцүүлэн биеийн тамир, спортын салбарын бодлогын үр нөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар бие бялдрын боловсролтой, ёс суртахууны төлөвшилтэй, эрүүл чийрэг иргэнийг төлөвшүүлэхэд оршино.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Иргэдийг эрүүл чийрэг байлгах, тэднийг биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх, их спорт, олимпын хөдөлгөөнийг сурталчлан дэлгэрүүлэх тамирчдын залгамж халааг бэлтгэнэ.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

- 1.Биеийн тамир, спорт бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангах
2. Спорт бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангах

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

1.Иргэдийн идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлж, эрүүл мэндээ хамгаалах, хичээллэх орчин нөхцлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох

2. Спортоор дамжуулан мэргэжлийн тамирчин бэлтгэх, тэмцээн уралдааны тоог нэмэгдүүлж, тамирчид, дасгалжуулагчдын ур чадварыг дээшлүүлэх, тив дэлхийд орон нутгийн нэрийг гаргах

ОРЧНЫ шинжилгээ

ДОТООД ОРЧИН	
Давуу тал	Сул тал
• Бие даасан яамтай болсон. • Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний бие даасан агентлагтай болсон. • Засаг захиргааны нэгжид Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төвтэй болсон. • Биеийн тамир, спортын чиглэлээр 19 спортын холбоо, клубүүд үйл ажиллагаа явуулж байна. • Биеийн тамирын байгууллагын барилгын спорт заалны шал үе шаттайгаар шинэчлэгдэж байна. • Спортын секц, дугуйланд хамрагдах хүүхдийн тоо, нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх иргэдийн тоо нэмэгдэж байна. • Улс, бүс, олон улсын тэмцээнд оролцсон Завхан аймгийн өсвөрийн шигшээ багийн тамирчдын амжилт нэмэгдэж байна.	• Сумдад ажиллах хүний нөөц, боловсон хүчин дутагдалтай • Сумдад биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөл, заал талбай, тоног төхөөрөмж дутагдалтай. • Сум орон нутагт сургалт, сурталчилгаа, мэдээ мэдээлэл дутмаг байна. • Сум орон нутагт мэргэжлийн дасгалжуулагч байхгүй, хамрагдах хүүхдийн тоо цөөн байна. • Төсвийн хүртээмжээс шалтгаалж спортын тэмцээн уралдаанд оролцох, зохион байгуулахад хүндрэлтэй байдаг.
ГАДААД	ОРЧИН
Боломж	Эрсдэл
• Биеийн тамир спортын тухай хууль шинэчлэн батлагдаж мөрдөгдөн ажиллаж байна. • Биеийн тамир, спортын салбарын ажилтны цалин 2023 оноос хойш 20 хувиар нэмэгдсэн. • Олон улсын спортын тэмцээн уралдаанд өсвөрийн тамирчдыг оролцуулж амжилт гаргах боломж нэмэгдсэн. • Хөрш улсуудад хүний нөөцийг чадавхжуулах сургалтад хамруулах боломж нэмэгдсэн.	• Салбарын бүртгэл, мэдээлэл, статистикийн мэдээ бүрдүүлэлт, ашиглалт хангалтгүй. • Техник, тоног төхөөрөмж хоцорсон. • Нарийн мэргэжлийн сургалт, мэдээлэл, арга зүйгээр хангах үйл ажиллагаа дутмаг. • Салбарын цахимжилт, мэдээллийн сан бүрдүүлэлт бүрэн хийгдээгүй.

Биеийн Тамир, Спортын Газрын 2025-2028 онд хэрэгжих стратеги төлөвлөгөө

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги (арга зам)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин				Санхүүгийн эх үүсвэр
				2025	2026	2027	2028	
Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спорт бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангах								
Үндсэн чиг үүргийн нэр: Иргэдийн идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлж, эрүүл мэндээ хамгаалах, хичээллэх орчин нөхцлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох								
Зорилт 1. Хүн амыг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх үүднээс нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх, эрүүл амьдрах хэв маягт суралцаж, дасгал хөдөлгөөнийг дадал хэвшил болгох иргэдийн тоог нэмэгдүүлэх	Арга хэмжээ 1. “Бие бялдрын түвшин тогтоох сорил” үйл ажиллагааг шинэлэг түвшинд зохион байгуулж, иргэдийн тоог нэмэгдүүлнэ.	Хамрагдсан иргэдийн хувь	5	8	10	12	15	БӨХ 5.0
	Арга хэмжээ 2. Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын үнэлгээг гаргаж, хангалтгүй дүн авсан иргэдийг спортоор хичээллэх орчин нөхцөлөөр хангана.	Хангалтгүй дүнтэй иргэдийн тоо	0	100	120	150	200	ОНТ, БӨХ
	Арга хэмжээ 3. Төрийн албан хаагчдад ажлын байрны дасгал тогтмол хийх орчин нөхцөлөөр хангаж ажлын байрны дасгалын тэмцээнийг тогтмол зохион байгуулна.	Тэмцээнд хамрагдах байгууллагын тоо	5	8	10	15	20	БӨХ, Бусад их үүсвэр 20.0
	Арга хэмжээ 4. Ууланд алхах иргэдийн тоог нэмэгдүүлж арга хэмжээг шат дараатай зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	4	6	8	10	12	ОНТ, БӨХ 40.0
	Арга хэмжээ 5. Биеийн тамирын арга хэмжээний	Зарлагдсан аяны тоо	1	2	3	4	5	ОНТ, БӨХ 80.0

	сарын аяныг тогтмол зохион байгуулна.							
Зорилт 2. Нийтийн биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлтэй хамтран ажиллах	Арга хэмжээ 1. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй фитнес клубүүдийн үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана.	Үйл ажиллагааны тоо	1	2	2	3	3	ОНТ, БӨХ 40.0
	Арга хэмжээ 2. 24 сумдыг, чийрэгжүүлэх, фитнес төвтэй болгож, тэдгээр төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх орон тооны болон орон тооны бус арга зүйчтэй болгоно.	Үйлчлүүлсэн иргэдийн хувь	0,5	0,6	0,8	1	1,2	ОНТ, ОНХС 40.0
	Арга хэмжээ 3. Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаа явуулдаг сайн дурын иргэд, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын үйл ажиллагаа дэмжиж хамтран ажиллана.	Үйл ажиллагааны тоо	2	4	6	8	10	ОНТ, БӨХ, Бусад их үүсвэр 80.0
Зорилт 3. Бүх насны иргэдийн дунд биеийн тамир, спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулах	Арга хэмжээ 1. Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн бие бялдарт тохирсон биеийн тамирын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, тэдгээрт харьяалагдах төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.	Үйл ажиллагааны тоо	5	6	6	8	8	ОНТ, БӨХ, Бусад их үүсвэр 80.0
	Арга хэмжээ 2. Оюутан, залуучуудруу чиглэсэн биеийн тамирын арга хэмжээг тогтмол зохион байгуулж, тэдгээрт харьяалагдах төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.	Үйл ажиллагааны тоо	0	2	3	4	5	ОНТ, БӨХ, Бусад их үүсвэр 40.0

	Арга хэмжээ 3. Төрийн албан хаагчид болон иргэдэд чиглэсэн биеийн тамир, спортын арга хэмжээ тогтмол зохион байгуулна.	Үйл ажиллагааны тоо	10	12	14	16	18	ОНТ, БӨХ, Бусад их үүсвэр 80.0
	Арга хэмжээ 4. Ахмад настанд чиглэсэн биеийн тамирын болон, спортын арга хэмжээ тогтмол зохион байгуулж, тэдгээрт харьяалагдах төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.	Спортын үйл ажиллагаанд хамрагдах ахмадын тоо	60	80	100	120	150	ОНТ, БӨХ, ОНХС Бусад их үүсвэр 40.0
Ерөнхий чиг үүргийн нэр: Спорт бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангах								
Үндсэн чиг үүргийн нэр: Спортоор дамжуулан мэргэжлийн тамирчин бэлтгэх, тэмцээн уралдааны тоог нэмэгдүүлж, тамирчид, дасгалжуулагчдын ур чадварыг дээшлүүлэх, тив дэлхийд орон нутгийн нэрийг гаргах								
Зорилт 4. Хөгжлийн бэршээлтэй иргэдийг дэмжиж спортын үйл ажиллагаанд татан оролцуулж, тэдгээрт чиглэсэн биеийн тамирын үйл ажиллагаа, орчин нөхцөлийг сайжруулж хамтран ажиллах	Арга хэмжээ 1. Аймгийн болон баруун бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын тэмцээн тогтмол зохион байгуулна.	Спортын тэмцээний тоо	1	2	3	4	5	ОНТ, БӨХ, ОНХС Бусад их үүсвэр 40.0
	Арга хэмжээ 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж, спортын секц дугуйлан, сургалтад тогтмол хамруулна.	Хамрагдах иргэдийн тоо	8	10	15	20	25	БӨХ 5.0
Зорилт 5.	Арга хэмжээ 1. Үндэсний спортын болон шагайн наадгайн улс бүсийн чанартай уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулна.	Тэмцээний тоо	4	5	5	7	8	ОНТ, БӨХ, ОНХС Бусад их үүсвэр 80.0

Үндэсний болон өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлж, сургалт дасгалжуулалт, үйл ажиллагааг өргөжүүлэх	Арга хэмжээ 2. Спорт холбоодоор дамжуулж, бүх насны иргэдийг үндэсний спортын секц дугуйлан, сургалтад тогтмол хамруулна.	Иргэдийн эзлэх хувь	1	1,5	1,5	2	2	ОНТ, БӨХ, ОНХС Бусад их үүсвэр 5.0
	Арга хэмжээ 3. Өвлийн спортын төрлүүдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг шат дараатай зохион байгуулж, тамирчдын тоог нэмэгдүүлэх	Тамирчдын тоо	0	20	40	60	80	ОНТ, БӨХ, ОНХС Бусад их үүсвэр 40.0
Зорилт 6. Өсвөрийн шигшээ багийн амжилтыг ахиулах зорилгоор спорт холбоодынх нь үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллах	Арга хэмжээ 1. Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн 8 төрлийн спортын холбоодтой хамтран Улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулна.	Тэмцээний тоо	1	3	4	5	6	ОНТ, БӨХ, ОНХС Бусад их үүсвэр 200.0
	Арга хэмжээ 2. Тамирчид, дасгалжуулагчдын амжилтыг үнэлж, жилд 1-2 удаа шагнаж урамшуулна.	Тамирчдын тоо	30	40	50	60	70	ОНТ, БӨХ, ОНХС Бусад их үүсвэр 120.0
	Арга хэмжээ 3. УАШТ-ээн болон олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдыг дэмжиж хамтран ажиллана.	Зарцуулсан төсвийн хувь	40	45	45	50	50	ОНТ, БӨХ, ОНХС Бусад их үүсвэр 100.0
Зорилт 7. Спортын төрлүүдийн тоог нэмэгдүүлж, шинээр үйл ажиллагаа явуулж буй спортын холбоодтой хамтран ажиллах	Арга хэмжээ 1. Шинээр үйл ажиллагаа явуулж буй спортын холбоог дэмжиж тэмцээн уралдааныг хамтран зохион байгуулна.	Тэмцээний тоо	0	1	2	2	3	ОНТ, БӨХ, ОНХС Бусад их үүсвэр 40.0
	Арга хэмжээ 2. Секц дугуйлан хичээллүүлэх, орчин нөхцөлөөр хангаж,	Бэлтгэл сургалтын тоо	0	1	2	2	3	ОНТ, БӨХ, ОНХС Бусад их үүсвэр 5.0

	хамтарсан бэлтгэл, сургалт зохион байгуулна.							
Зорилт 8. Баруун бүс болон бусад аймгуудын сайн жишгийг нэвтрүүлж, харилцан туршлага солилцож хамтран ажиллах	Арга хэмжээ 1. Баруун бүсийн аймгуудтай хамтран ажиллаж спортын, нөлөөллийн ажил, сургалт сурталчилгаа, арга хэмжээг зохион байгуулж, ажилчид, багш нар, дасгалжуулагчид, тамирчдыг өргөнөөр хамруулж ажиллана.	Спорт, нөлөөллийн ажлын тоо	1	2	3	3	4	ОНТ, БӨХ, ОНХС Бусад их үүсвэр 80.0
	Арга хэмжээ 2. Улаанбаатар хот болон Эрдэнэт, Дархан хотын БТСГ, Нийслэлийн спортын газар Дүүргүүдийн спорт хороодтой шифийн холбоо тогтоож тамирчид дасгалжуулагчдыг солилцож хамтран ажиллана.	Хамтран ажиллах байгууллагын тоо	0	1	2	3	4	ОНТ, БӨХ, ОНХС Бусад их үүсвэр 20.0
Зорилт 9. Гадаад харилцааг хөгжүүлж, ажилчид, багш, дасгалжуулагчид, тамирчдынхаа ур чадварыг дээшлүүлэх	Арга хэмжээ 1. Хөрш хоёр улс болон бусад улс оронд зохион байгуулагдаж буй спортын уралдаан тэмцээнд тамирчид дасгалжуулагчид, шүүгчдийг оролцуулж, тамирчдын ур чадварыг нэмэгдүүлнэ.	Оролцох тамирчдын тоо	10	15	20	25	30	ОНТ, БӨХ, ОНХС Бусад их үүсвэр 20.0
	Арга хэмжээ 2. Оросын холбооны улсын Тува хотын спортын ордонтой шифийн холбоо байгуулж хамтран ажиллана.	Хамтран ажиллах спортын төрлийн тоо	0	1	2	3	4	ОНТ, БӨХ, ОНХС Бусад их үүсвэр 50.0
	Арга хэмжээ 3. Олон улсын чанартай сургалт, хамтын ажиллагаанд салбарын багш, дасгалжуулагчдыг өргөнөөр хамруулж хамтран ажиллана.	Сургалтад хамрагдах ажилчид, багш дасгалжуулагчид, тамирчдын тоо	0	10	15	20	30	ОНТ, БӨХ, ОНХС Бусад их үүсвэр 50.0

Зорилт 10. Спортын заал талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, спортоор дамжуулан иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх	Арга хэмжээ 1. Спорт талбай цэцэрлэгт хүрээлэнгийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх орчин нөхцөлийг хангаж ажиллана.	Спорт талбай цэцэрлэгт хүрээлэнгийн тоо	15	16	17	18	19	ОНТ, БӨХ, ОНХС Бусад их үүсвэр 400.0
	Арга хэмжээ 2. Спорт заалнууд, Цэнгэлдэх хүрээлэнгийн засварын ажилд холбогдох байгууллагатай хамтран ажиллаж иргэдэд үйлчлэх хүртээмжийг бий болгоно.	Засварын үйлчилгээний тоо	2	4	4	5	5	ОНТ, БӨХ, ОНХС Бусад их үүсвэр 400.0